АПУ Дэйри

Байршил:	Монгол улс
Төслийн дугаар:	55290
Бизнесийн салбар:	Хүнсний үйлдвэрлэл
Мэдэгдлийн төрөл:	Хувийн хэвшил
Байгаль орчны ангилал:	
Хэлэлцэх хурлын огноо:	2024 оны 7 сарын 24
Төлөв байдал:	Судалгааны шатанд
ТХББ-г нийтэд ил тод болгосон огноо:	2024 оны 6 сарын 12

Төслийн танилцуулга

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) нь АПУ Дэйри ХХК-д 20 сая хүртэлх ам.доллартай тэнцэхүйц төгрөгийн урт хугацаат зээл олгоно. Уг зээлийн дүнд Уур Амьсгалын Өндөр Нөлөөллийн Түншлэл Хөтөлбөрийн хүрээнд Канад улсын засгийн газрын санхүүжилтээр олгогдох 2 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт багтсан болно. Тус Компани нь энэхүү зээлийн санхүүжилтээр сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, савлах хүчин чадлаа нэмэгдүүлэх, эрчим хүчний хэмнэлтийн өндөр стандартыг хангасан шинэ үйлдвэрийн байгууламж барих болон эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зарцуулна.

Төслийн зорилго

Энэхүү төсөл нь ЕСБХБ-ны Монгол Улсын хувьд баримтлах стратеги болох олборлох бус салбарыг дэмжиж, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх бодлогод нийцэж байна. Тус зээл нь Компанийн хүчин чадлыг өргөжүүлөх хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх замаар компанийн өсөлт, өрсөлдөх чадварыг дэмжихээс гадна Монголын сүүний фермерүүд болон малчдад уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ухаалаг мал аж ахуй эрхлэх арга барилыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

Шилжилтийн нөлөөлөл

Хүлээгдэж буй шилжилтийн нөлөөлөл (ХШН)-ийн оноо: 68

Төслийн шилжилтийн нөлөө нь ногоон ба хүртээмжтэй байдалд оруулах хувь нэмрээс бий болно. Төслийн хүрээнд Компани нь эрчим хүчний хэмнэлтийн шалгуурт нийцсэн шинэ үйлдвэрийн барилгыг барьж ашиглалтад оруулах бөгөөд дотоодын зах зээл дэх сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ухаалаг туршлагыг нэвтрүүлэх, фермерүүд малчдын уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх зорилготой тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ. Мөн алслагдмал хөдөө орон нутаг дахь цөөн тооны сарлагтай малчдад шинэ зах зээлд нийцэх ур чадвар, технологи зэргийг эзэмшүүлснээр тухайн нутаг дах хүний нөөцийн хөгжлийг дэмжинэ.

Харилцагчийн мэдээлэл

АПУ ДЭЙРИ ХХК

АПУ Дэйри ХХК нь 2014 оноос эхлэн сүү, сүүн бүтээгдэхүүний иж бүрэн хэмжээний үйлдвэрлэл эрхэлж байгаа улсдаа тэргүүлэгч үйлдвэрлэгчдийн нэг бөгөөд Монголын хамгийн том, ууган шингэн хүнс үйлдвэрлэгч, борлуулагч АПУ ХК-ийн бүрэн өмчит охин компани юм.

ЕСБХБ-ны санхүүжилтийн дүн

20,000,000.00 ам.доллар

Төслийн нийт өртөг

53,000,000.00 ам.доллар

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны тойм

Б ангилал (2019 БОНБ).

ЕСБХБ-аас байгаль орчин, нийгмийн (БОН) зохих магадлан шинжилгээг хийж, компанийн үйлдвэрийн байгууламжууд болон бэлтгэн нийлүүлэгч малчдын төлөөлөлтэй танилцсан. Компани нь өөрийн болон АПУ ХК-ийн түвшинд БОН асуудлыг удирдан шийдвэрлэхэд зохих боловсон хүчнийг томилж ажиллуулдаг. АПУ ХК нь 2030 он хүртэл баримтлах Тогтвортой Хөгжлийн Стратеги баримт бичиг нарийвчлан боловсруулж, танилцуулах шатандаа явж байгаа бөгөөд үүнд компанийн удирдлагын тогтолцоог хянаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт гэрчилгээ нэвтрүүлэх төлөвлөгөөг багтаасан байна. Компани нь чанарын ISO 9001, хүнсний аюулгүй байдлын FSSC 22000 зэрэг албан ёсны удирдлагын тогтолцоог өмнө нь нэвтрүүлсэн.

Хүний нөөцийн менежментийн хувьд, Компани нь Гүйцэтгэлийн шаардлага 2-ын дагуу Компанийг удирдах зохих боловсон хүчин ба бодлого хэрэгжүүлж

ажиллаж байна. Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөний (БОНҮАТ) хүрээнд Компанид эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх хүсэлтийг тавих болно. Компани гол оролцогч талуудаа тодорхойлж, тэдэнтэй харилцах төлөвлөгөөг боловсруулсан. Мөн компани өөрийн бэлтгэн нийлүүлэгч малчдын өргөн сүлжээтэй харилцах хөтөлбөртэй ба ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх логистик, чанарын стандартыг хангахад туслах малчид, фермерүүдтэй харилцах тусгай ажиллах хүний нөөцтэй. Энэхүү харилцах хөтөлбөрөөр дамжуулан Компани сүүний үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, улмаар ханган нийлүүлэлтийн сүлжээтэй холбоотой байгаль орчин, уур амьсгалын нөлөөллийг бууруулахад чиглэсэн зөвлөх үйлчилгээний хөтөлбөрийг дамжуулан олгох боломжтой юм.

ЕСБХБ Компанитай хамтран БОНҮАТ-г магадлан шинжилгээний үр дүнг шийдвэрлэх, ялангуяа гол БОН асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Компанийн дотоод бодлого, практикийг цаашид хөгжүүлэх үүднээс боловсруулсан болно. Тодруулбал, үндсэн үйл ажиллагааны төлөв нь АПУ ХК Тогтвортой хөгжлийн стратеги бодлого боловсруулан хэрэгжүүлсний үр дүнд тодорхой болох юм. Компани нь БОНҮАТ-ний хэрэгжилт болон Банкны Гүйцэтгэлийн шаардлагуудын заалтуудтай уялдаж байгаа эсэх талаар жил бүр тогтмол тайлагнах болно.

Техникийн хамтын ажиллагаа

Төсөл нь дараах техникийн хамтын ажиллагаанаас ашиг тус хүртэх болно:

i) Уур Амьсгалын Өндөр Нөлөөллийн Түншлэл Хөтөлбөрийн хүрээнд Канад Улсын санхүүжилтээр хэрэгжих техникийн хамтын ажиллагааг Компани болон Монголын сүүний үйлдвэрийн холбоо хамтран хэрэгжүүлж сүүний фермерүүдэд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ухаалаг аж ахуйг нэвтрүүлэхэд чиглэсэн тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;

ii) Хууль эрх зүйн магадлан шинжилгээг Япон-ЕСБХБ-ны хамтын ажиллагааны сангаас (JECF) хэсэгчлэн санхүүжүүлнэ.

Банкны Оролцоо

ЕСБХБ нь дотоодын арилжааны банкны санхүүжилтэд дутагдаж байгаа боломжийн нөхцөл бүхий их хэмжээний хөрөнгө оруулалтын хэрэгцээний орон зайг нөхөх бөгөөд энэхүү зээлийн санхүүжилт нь тогтвортой байдлын үнэлгээнд суурилсан зээлийн хүүгийн түвшинтэй учир Монгол Улсын хувьд маш шинэлэг зээлийн бүтээгдэхүүн гэдгээрээ онцлогтой. Компани нь уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдал болон жендерийн эрх тэгш байдлын талаарх Банкны туршлагаас мөн хүртэх болно.

Компанитай холбоо барих мэдээлэл

Анударь Ганбаатар
anudari.g@apu.mn
99083474
https://www.apudairy.mn/

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг эндээс авна уу.

Бизнес боломжууд

Бизнес боломжууд болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авалттай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168
Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл ЕСБХБ-ны Худалдан авалт хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794
Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг ЕСБХБ-ны Лавлагааны маягт ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

БОНБ болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д үйлчлүүлэгчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх , мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа үйлчлүүлэгч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг

гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн, тухайн төслийн улмаас үүсэх эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх нэмэлт шаардлагыг үйлчлүүлэгчиддээ тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг БОНБ-д оруулсан болно.

Бүрэн төгс байдал ба комплаенс

ЕСБХБ-ны Комплаенс хариуцсан Захирлын Ажлын алба (КЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг практикт нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаан дахь бүрэн төгс байдлыг хамгийн дээд стандартаар хангахад анхаарч ажилладаг. Төслүүдийн зүгээс Банкинд бүрэн төгс байдал, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд тус Банк бүх үйлчлүүлэгчийнхээ бүрэн төгс байдалд нарийвчилсан үнэлгээ хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны транзакцийн бүрэн төгс байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. КЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, мөн төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах бүрэн төгс байдлын эрсдлийг хянахад тус дөхөм үзүүлдэг.

Түүнчлэн, КЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга, хээл хахууль болон буруу үйлдлийн талаарх гомдлын мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд, эсвэл гадна байгаа хэн ч бай залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй тохиолдолд Комплаенс хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаяг руу бичгээр илтгэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг КЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүх мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алинаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь чин сэтгэлийн байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги,

бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны вэб сайтаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл Мэдээллийн хүртээмжийн бодлого хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ ЕСБХБ-ны Лавлагааны маягт ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо үйлчлүүлэгч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: үйлчлүүлэгчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн Байгаль орчин, нийгмийн бодлого, эсвэл Мэдээллийн хүртээмжийн бодлого–ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний эрх үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб сайт, хянан шалгуулах хүсэлт тавих бол Хүсэлт хаягаар тус тус хандана уу. Эсвэл ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол ipam@ebrd.com цахим шуудангаар хандаж болно.